



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/230

Чингис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт болон Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2016 оны дөрөвдүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 5 дугаар баг, Тариаланчидын гудамж Цэвэрлэх байгууламжийн баруун талд байрлах 15255 м² газрыг, төрийн үйлчилгээний зориулалтаар Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газарт 52 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Мал эмнэлгийн газрын эзэмшиж буй газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/399 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралтын 11, 13 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

10624